



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/146-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: <a href="mailto:urtaa6969@gmail.com">urtaa6969@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 2 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ П.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

2025. 02. 25 № САА-2025/146-НА-САА-ТМЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 20,567.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>145,263,744.00</b>	<b>153,843,709.56</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>97,429,641.00</b>	<b>111,852,799.506</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>97,429,641.00</b>	<b>111,852,799.56</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>97,429,641.00</b>	<b>111,852,799.506</b>
31211	Төрийн сангийн харилцах	97,429,641.00	111,852,799.56
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>47,834,103.00</b>	<b>41,990,910.00</b>
351	Түүхий эд материал	2,753,898.00	134,500.00
3511	Тусгай зориулалттай материал	2,669,398.00	0.00
3513	Эм боох материал	84,500.00	134,500.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>45,080,205.00</b>	<b>41,856,410.00</b>
35410	Бичиг хэргийн материал	629,900.00	464,900.00
35450	Барилгын засварын материал	636,200.00	2,986,200.00
35470	Бусад хангамжийн материал	43,814,105.00	38,405,310.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,598,495,264.32</b>	<b>1,569,588,499.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,598,495,264.32</b>	<b>1,569,588,499.95</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,503,919,014.46</b>	<b>1,473,948,499.95</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,529,386,746.00	1,529,386,746.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(115,774,831.56)	(145,439,619.48)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,062,144.46	68,754,742.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,708,330.62)	(35,147,985.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,010,876.94	28,861,523.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,769,171.44)	(13,331,634.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,337,844.00	67,337,844.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,626,263.32)	(26,473,116.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>94,576,249.86</b>	<b>95,640,000.00</b>
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,403,750.14)	(340,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	94,330,000.00	94,330,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,743,759,008.32</b>	<b>1,723,432,209.51</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>777,822.47</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>777,822.47</b>
413	Өглөг	0.00	777,822.47
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	777,822.47
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,743,759,008.32</b>	<b>1,722,654,387.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,743,759,008.32</b>	<b>1,722,654,387.04</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	400,803,767.00	400,803,767.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,180,512,176.88</b>	<b>1,159,407,555.60</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,180,512,176.88	1,180,512,176.88
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-21,104,621.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	162,443,064.44	162,443,064.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,743,759,008.32</b>	<b>1,723,432,209.51</b>

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,371,000.00</b>	<b>3,060,700.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,371,000.00	3,060,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>72,717,861.49</b>	<b>84,527,438.47</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,342,953.00	27,764,806.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,117,200.00	8,912,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,257,708.49	47,850,032.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,841,100.00</b>	<b>13,368,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,841,100.00</b>	<b>13,368,900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,841,100.00	13,368,900.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>170,542,237.91</b>	<b>-21,104,621.28</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>170,542,237.91</b>	<b>-21,104,621.28</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>975,266,019.74</b>	<b>1,299,305,089.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>111,303,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>111,303,800.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>111,303,800.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
122	Тусламжийн орлого	0.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>975,266,019.74</b>	<b>1,294,305,089.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>885,334,600.00</b>	<b>1,213,486,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,334,600.00	1,213,486,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>89,931,419.74</b>	<b>80,818,389.08</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,931,419.74	80,818,389.08
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>873,572,884.34</b>	<b>1,272,683,230.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>873,572,884.34</b>	<b>1,272,683,230.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>855,731,784.34</b>	<b>1,259,314,330.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>586,623,180.65</b>	<b>931,413,275.14</b>
210101	Үндсэн цалин	392,221,607.73	585,251,158.00
210102	Нэмэгдэл	161,857,259.94	286,505,909.93
210104	Урамшуулал	32,544,312.98	59,656,207.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,940,410.95</b>	<b>117,891,190.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,175,945.91	81,730,960.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,784,808.95	9,735,203.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,752,842.08	4,810,713.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,704.92	4,322,738.87
210205	Эрүүл мэндийн даатгал	12,944,109.09	17,291,574.41

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,090,585,886.74</b>	<b>1,306,049,657.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>115,319,867.00</b>	<b>11,744,568.10</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>115,319,867.00</b>	<b>11,744,568.10</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>5,000,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	115,219,867.00	6,744,568.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	100,000.00	0.00
122	Тусламжийн орлого	0.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>975,266,019.74</b>	<b>1,294,305,089.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>885,334,600.00</b>	<b>1,213,486,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	885,334,600.00	1,213,486,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>89,931,419.74</b>	<b>80,818,389.08</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,931,419.74	80,818,389.08
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>920,043,648.83</b>	<b>1,327,154,278.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>920,043,648.83</b>	<b>1,327,154,278.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>902,202,548.83</b>	<b>1,313,785,378.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>586,623,180.65</b>	<b>932,191,097.61</b>
210101	Үндсэн цалин	392,221,607.73	586,028,980.47
210102	Нэмэгдэл	161,857,259.94	286,505,909.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,544,312.98	59,656,207.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,940,410.95</b>	<b>117,891,190.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,175,945.91	81,730,960.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,784,808.95	9,735,203.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,752,842.08	4,810,713.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,704.92	4,322,738.87
210205	Эрүүл мэндийн даатгал	12,944,109.09	17,291,574.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>77,214,824.74</b>	<b>58,171,089.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,147,116.74	8,805,773.08
210302	Түлш, халаалт	41,786,287.00	35,695,829.00
210303	Цэвэр, бохир ус	27,281,421.00	13,669,487.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,108,551.00</b>	<b>0.00</b>
210408	Бараа материал акталсны зардал	2,108,551.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,406,720.00</b>	<b>97,646,563.00</b>
210502	Хоол, хүнс	80,406,720.00	97,646,563.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,820,000.00</b>	<b>20,297,300.00</b>
210604	Урсгал засвар	5,820,000.00	20,297,300.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>84,111,419.74</b>	<b>58,171,089.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,147,116.74	8,805,773.08
210302	Түлш, халаалт	41,786,287.00	35,695,829.00
210303	Цэвэр, бохир ус	34,178,016.00	13,669,487.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78,870,720.00</b>	<b>97,646,563.00</b>
210502	Хоол, хүнс	78,870,720.00	97,646,563.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,820,000.00</b>	<b>22,647,300.00</b>
210604	Урсгал засвар	5,820,000.00	22,647,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,371,000.00</b>	<b>3,060,700.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,371,000.00	3,060,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,995,053.00</b>	<b>28,484,213.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,877,853.00	19,571,613.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,117,200.00	8,912,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,841,100.00</b>	<b>13,368,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,841,100.00</b>	<b>13,368,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,841,100.00	13,368,900.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>101,693,135.40</b>	<b>26,621,858.50</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,906,700.00</b>	<b>12,198,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,906,700.00</b>	<b>12,198,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,906,700.00</b>	<b>12,198,700.00</b>
222001	Тоног төхөөрөмж	0.00	12,198,700.00
223001	Бусад хөрөнгө	10,906,700.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(10,906,700.00)</b>	<b>(12,198,700.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>90,786,435.40</b>	<b>14,423,158.56</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		97,429,641.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		111,852,799.56

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,803,767.00	162,443,064.44	1,180,512,176.88	1,743,759,008.32
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-21,104,621.28	-21,104,621.28
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,803,767.00	162,443,064.44	1,159,407,555.60	1,722,654,387.04

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	увь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,412,456,000.00</b>	<b>1,284,881,930.52</b>	<b>127,574,069.48</b>	91.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,412,456,000.00</b>	<b>1,272,683,230.52</b>	<b>139,772,769.48</b>	90.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,399,087,100.00</b>	<b>1,259,314,330.52</b>	<b>139,772,769.48</b>	90.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,027,586,600.00</b>	<b>931,413,275.14</b>	<b>96,173,324.86</b>	90.6
210101	Үндсэн цалин	671,445,900.00	585,251,158.00	86,194,742.00	87.2
210102	Нэмэгдэл	318,214,800.00	286,505,909.93	31,708,890.07	90.0
210104	Урамшуулал	37,925,900.00	59,656,207.21	(21,730,307.21)	157.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>121,354,700.00</b>	<b>117,891,190.30</b>	<b>3,463,509.70</b>	97.1
210201	Тэтгэврийн даатгал	82,523,000.00	81,730,960.64	792,039.36	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,706,600.00	9,735,203.10	(28,603.10)	100.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,854,100.00	4,810,713.28	43,386.72	99.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,854,100.00	4,322,738.87	531,361.13	89.1
210205	Эрүүл мэндийн даатгал	19,416,900.00	17,291,574.41	2,125,325.59	89.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,892,500.00</b>	<b>58,171,089.08</b>	<b>20,721,410.92</b>	73.7
210301	Гэрэл, цахилгаан	9,138,200.00	8,805,773.08	332,426.92	96.4
210302	Түлш, халаалт	48,754,200.00	35,695,829.00	13,058,371.00	73.2
210303	Цэвэр, бохир ус	21,000,100.00	13,669,487.00	7,330,613.00	65.1
2105	<b>Нормативт зардал</b>	<b>106,691,400.00</b>	<b>97,646,563.00</b>	<b>9,044,837.00</b>	91.5
210502	Хоол, хүнс	106,691,400.00	97,646,563.00	9,044,837.00	91.5
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,647,300.00</b>	<b>22,647,300.00</b>	<b>0.00</b>	100.0
210604	Урсгал засвар	22,647,300.00	22,647,300.00	0.00	100.0

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,060,700.00</b>	<b>3,060,700.00</b>	<b>0.00</b>	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,060,700.00	3,060,700.00	0.00	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,853,900.00</b>	<b>28,484,213.00</b>	<b>10,369,687.00</b>	73.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,941,300.00	19,571,613.00	10,369,687.00	65.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,912,600.00	8,912,600.00	0.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,368,900.00</b>	<b>13,368,900.00</b>	<b>0.00</b>	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,368,900.00</b>	<b>13,368,900.00</b>	<b>0.00</b>	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,368,900.00	13,368,900.00	0.00	100.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>12,198,700.00</b>	<b>(12,198,700.00)</b>	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	12,198,700.00	(12,198,700.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	12,198,700.00	(12,198,700.00)	
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,000,000.00</b>	<b>1,299,305,089.02</b>	<b>(1,294,305,089.02)</b>	25,986.1
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>1,107,182,899.94</b>	<b>(1,107,182,899.94)</b>	
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	1,107,182,899.94	(1,107,182,899.94)	
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>80,818,389.08</b>	<b>(80,818,389.08)</b>	
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>0.00</b>	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>106,303,800.00</b>	<b>(106,303,800.00)</b>	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		97,429,641.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		111,852,799.50	0.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих боломжтой, сонирхол хэрэгцээг дэмжсэн суралцах орчин байна” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүр бүр бодит, чөлөөтэй орчинд тоглонгоо хөгжих,
- Хүүхэд өөрийн сонирхол сонголтоор дуртай зүйлээ хийх
- Хүүхэд бүр бусадтай хамтран тоглох, зохицон харилцах, орчин тойрны бодит юмстай танилцан суралцах, мэдлэг бүтээх, бүтээлч үйлээрээ хөгжих чадварт суралцах гэсэн зорилтыг тавин ажилласан.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,326.8 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97,429.6	111,852.8	14,423.2
Авлага			
Бараа материал	47,834.1	41,990.9	(5,843.2)
Үндсэн хөрөнгө	1,598,495.3	1,569,588.5	(28,906.8)
Нийт хөрөнгө	<b>1,743,759.0</b>	<b>1,723,432.2</b>	<b>(20,326.8)</b>
Өр төлбөр		777.8	777.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,743,759.0	1,722,654.4	(21,104.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,743,759.0</b>	<b>1,723,432.2</b>	<b>(20,326.8)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 111,852.8 мянган төгрөг болж 14,423.2 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 41,990.9 мянган төгрөг болж 5,843.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 139,737.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаанд 145,580.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,790,320.8 мянган төгрөг болж 456.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 12,198.7 мянган төгрөгийн компьютер, гал тогооны тоног төхөөрөмж худалдан авсан, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 362, 12-р сарын 31-ний өдрийн 479 дүгээр албан бичгүүдээр ашиглалтын хугацаа нь дууссан дахин ашиглах боломжтой өртгөө бүрэн нөхсөн 5,494.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 1,250.0 мянга төгрөгийн санхүүгийн программыг дахин үнэлж бүртгэсэн, сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 362 дугаар тогтоолын дагуу 8,992.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, 47,850.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 777.8 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан ХХОАТ-ыг дутуу шилжүүлснээс тус тус шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,377,614.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 98,213.5 мянган төгрөг нийт 1,475,828.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 497,064.4 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 60,067.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 49,603.5 мянган төгрөгөөр нийт 606,735.3 мянган төгрөгөөр бууруулж төсвийг нийт 869,092.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 461,373.2 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 31,441.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 16,620.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 30,602.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 3,325.3 мянган төгрөгөөр нийт 543,363.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,199,064.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 101,538.8 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 111,852.8 мянган төгрөг буюу нийт 1,412,456.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,412,456.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,284,881.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,284,881.9 мянган төгрөг буюу 91.0 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 9,044.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 118,529.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	<b>71802- Сургуулийн өмнөх боловсрол</b>	1	80233- Хүүхэд хамгаалал	1,358.0	1,358.0	0.0	100.0
		2	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,060.4	2,060.0	0.4	100.0
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол хөтөлбөр	106,691.4	97,646.6	9,044.9	91.5
		4	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,322.5	3,322.5	0.0	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	2,056.8	1,550.0	506.8	75.4
		6	81834- Боловсролын стандарт сургалт	1,137,697.7	1,040,408.3	97,289.4	91.4
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	52,730.4	52,718.2	12.2	100.0
		8	83603- Дэд шатны төсвөөс хуваарилсан	5,000.0	5,000.0	0.0	100.0
		9	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	101,538.8	80,818.4	20,720.4	79.6
		<b>Нийт</b>		<b>1,412,456.0</b>	<b>1,284,881.9</b>	<b>127,574.1</b>	<b>91.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланг худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 75,250.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч, оролцогч

ирээгүйгээс “Эх наран булаг” ХХК “Шанзан ташуур” ХХК, “Шинэ шүүдэр” ХХК, “Сая сарнай” ХХК, “Ноцох дөл” ХХК-иудтай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундарьяа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 920,043.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,200.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,

- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 164 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

- Санхүүгийн тайлан-1
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-1
- Байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлт-3
- Аудитын тайлан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ-1
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт-1

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар багш нарыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэлгүйгээр 5,336.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон зөрчилд 1 нөхөн төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 6,887.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5,336.5	1	5,336.5	100.0
Албан шаардлага	1	6,887.4	1	6,887.4	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>12,223.9</b>	<b>2</b>	<b>12,223.9</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,555.6 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 777.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 777.8 мянган төгрөгөөр тус тус дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, 14.4.3. “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт **30,833.4** мянган төгрөгийн зөрчил илэрч 495.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 777.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 29,560.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаарын сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч С.Шинэбаяр, нярав Л.Эрдэнэтуяа нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 495.5 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “*Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*”, 14.2.3 дахь “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*” Засгийн газрын 2024 оны “*Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай*” 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 777.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй бэлтгэсэн 29,560.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 <sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд өр төлбөр дутуу тусгасан	1	777.8	1	777.8			1	777.8				
Цалингийн зардал дутуу тусгасан	1	777.8	1	777.8			1	777.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,555.6</b>	<b>2</b>	<b>1,555.6</b>			<b>2</b>	<b>1,555.6</b>				

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	495.5	1	495.5								
Өглөг үүсгэсэн	1	777.8			1	777.8						
Үнэ төлбөргүй бараа материал тусгаагүй	1	29,560.1					1	29,560.1				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>30,833.4</b>	<b>1</b>	<b>495.5</b>	<b>1</b>	<b>777.8</b>	<b>1</b>	<b>29,560.1</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээ хоцроосон	1							1
<b>Нийт</b>	<b>1</b>							<b>1</b>

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.